



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/1/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 154

танай _____ ны № _____ т

БАЯННУУР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ЖИГМЭД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын 1 хөтөлбөр 7 арга хэмжээний хүрээнд нийт 1,049.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 937.8 сая төгрөгийг зарцуулж, 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 8 бүлэг бүхий 44 арга хэмжээний хэрэгжилт 88.5 хувьтай үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудлууд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй. Тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ нь ОНХС болон бусад эх үүсвэрээс шилжиж ирсэн үндсэн хөрөнгө болон элэгдлээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж, орлого авсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

6326050128

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/ төгрөгөөр/

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	13,261,394.4	8,767,212.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,462,313,323.5	3,165,543,462.1
	Нийт хөрөнгийн дүн	2,475,574,717.8	3,174,310,674.4
	Нийт өр төлбөрийн дүн	935,000.0	363,000.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,474,639,717.8	3,173,947,674.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,475,574,717.8	3,174,310,674.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,026,629,200.0	1,672,489,839.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,086,235,235.2	1,162,841,549.5
	Үйл ажиллагааны үр дүн	(59,606,035.2)	509,648,289.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(59,606,035.2)	509,648,289.8
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	2,474,639,717.8
	Тайлант оны үр дүн	-	509,648,289.8
	Эцсийн үлдэгдэл	2,474,639,717.8	3,173,947,674.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,026,629,200.0	1,003,423,767.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,020,544,400.0	976,581,567.0
	Үйл ажиллагааны ЦМГ	6,084,800.0	26,842,200.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(6,084,800.0)	(26,842,200.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	937,783,482.5
	Урсгал зардал	-	937,783,482.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	998,038,100.0
	Орон нутгийн төсвөөс	-	996,633,100.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	1,405,000.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 37.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын залрууллаа.

Залруулсан алдаа:

- Төрийн албан хаагчийн орон сууцны барилгын засварын цахилгаан хангамжийн 36.0 сая төгрөгийн нэмэлт ажлыг Орон нутгийн төсвөөс хэрэгжүүлж аймгийн ЗД-ын 2025 оны 10 дугаар сарын 29-ний А/686 дугаар захирамжаар хөрөнгийг бүртгэлд тусгах шийдвэр гарсан ч байнгын ашиглагч байгууллагад тус шийдвэр ирээгүй, ажлыг хүлээж аваагүйгээс

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

хөрөнгийн үнэлгээг нэмэгдүүлээгүй нь УСНББОУС-17, үнэлгээ ба хуваарилалт,

- Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 1.7 сая төгрөгийг авлагаар тусгаагүй нь УСНББОУС-1, 2, тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж
- мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт 12.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 0.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 9.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 2.3 сая төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 12.5 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3.8 сая төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Урд бүсийн сумдын Засаг даргын тамгын газрын спортын нөхөрсөг тэмцээнд оролцооны үнэ 0.9 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д *"Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:"* 15.1.8-д *"байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах."* гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны дотор орон нутгийн орлого болгох.

5.2 Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс 9.3 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт бус зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1-т "Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож холбогдох хууль, журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж төсвийг зориулалтын дагуу зарцуулах, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 15-ны дотор биелэлт ирүүлэх

5.3 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Жилийн эцсийн тооллогоор 2.3 сая төгрөгийн бараа материалыг үнэн зөв чанартай тоолоогүй, анхан шатны баримтын бүрдэд дутуу байна.

Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 12.3, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2-т заасны дагуу баримтын бүрдлийг бүрэн хангасан тооллого явуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган.төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн албан хаагчийн орон сууцны барилгын үнэлгээг нэмэгдүүлээгүй байна.	1	36,000.0	1	36,000.0			1	36,000.0				
Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 1,700.0 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй	1	1,700.0	1	1,700.0			1	1,700.0				
Дүн	2	37,700.0	2	37,700.0	0	-	2	37,700.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын нөөц хөрөнгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт бус зарцуулсан	1	9,334.1			1	9,334.1						
Урьд бүсийн төрийн албан хаагчдын тэмцээний шагналд 900.0 мянган төгрөгийн бооцооны мөнгийг төсвөөс зарцуулсан	1	900.0	1	900.0								
Жилийн эцсийн тооллогын баримтын бүрдэл дутуу	1	2,264.8					1	2,264.8				
Дүн	3	12,498.9	1	900.0	1	9,334.1	1	2,264.8	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	0	-	0	-	0	-	0	-
Дүн	0	-	0	-	0	-	0	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	-	0	-	0	-	0	-
Нийт дүн	0	-	0	-	0	-	0	-

-oOo-